

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/109/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр

2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Б.Авидцэрэн

Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МСЭМХ	Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арванхоёр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7132 3253
E-mail: ovorkhangai@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.ШИВААННҮРДЭВ ТАНАА

Тайлан № 2021/02/23-Нө
Тайлан № 2021/02/23-Нө

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	330,501,271.46	921,386,400.71
33	АВЛАГА	3,154,291.81	16,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,154,291.81	0.00
33101	Цалингийн авлага	1,700,000.00	0.00
33102	НДШ-ийн авлага	1,454,291.81	0.00
33500	Бусад авлага	0.00	16,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	16,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	327,346,979.65	905,386,400.71
35100	Түүхий эд материал	290,845,849.75	867,853,070.81
35110	Тусгай зориулалттай материал	290,845,849.75	867,853,070.81
35400	Хангамжийн материал	36,501,129.90	37,533,329.90
35410	Бичиг хэргийн материал	1,132,814.00	1,335,314.00
35420	Аж ахуйн материал	19,207,715.90	19,207,715.90
35440	Түлш, шатах тослох материал	8,745,000.00	7,910,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,415,600.00	9,080,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	720,028,631.10	949,595,434.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	720,028,631.10	949,595,434.41
39200	Биет хөрөнгө	698,788,631.10	928,355,434.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	526,900,493.01	600,910,693.01
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(14,730,299.76)	(20,678,924.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	214,615,480.00	214,615,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(133,015,479.86)	(158,648,813.18)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	206,144,692.34	315,017,609.88
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(138,262,957.21)	(155,713,790.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,766,765.41	75,766,765.41
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(38,630,062.83)	(44,903,385.39)
	Дуусаагүй барилга, байгууламж		101,989,800.00
39300	Биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,050,529,902.56	1,870,981,835.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,050,529,902.56	1,870,981,835.12
51	Засгийн газрын хувь оролцоо	1,050,529,902.56	1,870,981,835.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	667,991,433.00	667,991,433.00
51200	Хуримтлагдсан үр дүн	60,080,052.02	880,531,984.58
51210	Өмнөх үеийн үр дүн	(237,511,847.79)	60,080,052.02
51220	Тайлант үеийн үр дүн	297,591,899.81	820,451,932.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,458,417.54	322,458,417.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,050,529,902.56	1,870,981,835.12

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,165,273,650.20	13,053,401,278.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	534,334,890.20	8,309,766,758.06
1200	Нийтлэг татварын бус орлого	534,334,890.20	8,309,766,758.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	534,334,890.20	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	534,334,890.20	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	272,040,017.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	8,037,726,740.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,630,938,760.00	4,743,634,520.17
1310	Улсын төсвөөс	2,216,976,300.00	2,495,512,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,216,976,300.00	2,495,512,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,106,660.00	2,248,122,420.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	217,749,060.00	159,976,594.17
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	305,859,416.00
131104	доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	29,857,600.00	1,640,667,545.00
131105	болсон нэмэлт орлого	2,500,000.00	141,618,865.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,855,800.00	-
132001	байгууллага/	163,855,800.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,850,439,332.08	12,232,949,345.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,850,439,332.08	12,232,949,345.67
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,737,077,032.08	9,037,902,158.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	522,697,700.00	594,175,233.00
210101	Үндсэн цалин	325,972,400.00	330,469,600.00
210102	Нэмэгдэл	112,171,300.00	170,500,233.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	43,890,000.00	43,890,000.00
210104	Урамшуулал	40,664,000.00	49,315,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,198,593.19	75,837,791.81
210201	Тэтгэврийн даатгал	50,574,830.19	54,148,716.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,409,259.00	5,341,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,433,574.00	4,359,380.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,070,957.00	1,089,845.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,709,973.00	10,898,350.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,872,500.00	42,699,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,608,200.00	5,164,500.00
210302	Түлш, халаалт	25,512,000.00	34,369,900.00
210303	Цэвэр, бохир ус	752,300.00	3,165,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,986,300.00	46,390,106.00
210401	Бичиг хэрэг	10,515,300.00	6,910,100.00
210402	Тээвэр, шатахуун	32,380,400.00	30,703,656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,873,100.00	3,354,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,442,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,217,500.00	3,979,250.00
2105	Нормативт зардал	701,370,755.44	7,965,026,180.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	701,370,755.44	7,965,026,180.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,274,700.00	26,787,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,782,000.00	-
210604	Урсгал засвар	6,492,500.00	26,787,300.00
2107	Томилолт, зочны зардал	8,914,000.00	40,459,900.00
210702	Дотоод албан томилолт	8,914,000.00	40,459,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,155,100.00	10,794,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	592,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,728,400.00	1,728,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	311,100.00	311,100.00

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,448,600.00	8,588,200.00
210807	Газрын төлбөр	75,000.00	75,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	59,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,607,383.45	235,731,747.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,470,260.00	26,742,660.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	62,667,100.00	153,682,973.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	64,470,023.45	55,306,114.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,113,362,300.00	3,195,047,187.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	754,236.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	754,236.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,112,608,064.00	3,195,047,187.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,471,300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	64,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	620,748,864.00	446,706,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	491,099,200.00	1,103,496,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	109,343,787.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,190,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	314,834,318.12	817,618,882.56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	17,190,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	17,190,000.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	17,190,000.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	297,644,318.12	820,451,932.56

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	667,991,433.00	322,458,417.54	60,080,052.02	1,050,529,902.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,991,433.00	322,458,417.54	(237,511,847.79)	752,938,002.75
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн	-	-	820,451,932.56	820,451,932.56
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,991,433.00	322,458,417.54	582,940,084.77	1,573,389,935.31

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,630,938,760.00	4,743,634,520.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,630,938,760.00	4,743,634,520.17
1310	Улсын төсвөөс	2,216,976,300.00	2,495,512,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,216,976,300.00	2,495,512,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,106,660.00	2,248,122,420.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	217,749,060.00	159,976,594.17
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	305,859,416.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	29,857,600.00	1,640,667,545.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00	141,618,865.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,855,800.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,855,800.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,550,244,460.00	4,730,801,620.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,550,244,460.00	4,730,801,620.17
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,882,160.00	1,535,754,433.17
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	521,818,700.00	592,475,233.00
210101	Үндсэн цалин	325,093,400.00	328,769,600.00
210102	Нэмэгдэл	112,171,300.00	170,500,233.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	43,890,000.00	43,890,000.00
210104	Урамшуулал	40,664,000.00	49,315,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,838,000.00	74,383,500.00
210201	Тэтгэврийн даатгал	49,145,300.00	53,017,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,173,200.00	5,341,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,138,500.00	4,273,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,034,600.00	1,068,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,346,400.00	10,682,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,872,500.00	42,699,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,608,200.00	5,164,500.00
210302	Түлш, халаалт	25,512,000.00	34,369,900.00
210303	Цэвэр, бохир ус	752,300.00	3,165,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,329,600.00	74,548,500.00
210401	Бичиг хэрэг	7,692,800.00	6,957,600.00
210402	Тээвэр, шатахуун	41,125,400.00	28,953,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,873,100.00	3,354,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,442,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,638,300.00	33,840,400.00
2105	Нормативт зардал	408,451,200.00	461,064,061.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	406,512,000.00	458,478,361.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,939,200.00	2,585,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,715,700.00	45,370,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,223,000.00	2,673,000.00
210604	Урсгал засвар	6,492,500.00	42,497,300.00
2107	Томилолт, зочны зардал	8,914,000.00	40,459,900.00
210702	Дотоод албан томилолт	8,914,000.00	40,459,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,155,100.00	10,794,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	592,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,728,400.00	1,728,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	311,100.00	311,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,448,600.00	8,588,200.00
210807	Газрын төлбөр	75,000.00	75,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	59,400.00

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	279,787,360.00	193,959,039.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	217,120,260.00	39,683,770.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	62,667,100.00	154,275,269.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,113,362,300.00	3,195,047,187.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	754,236.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	754,236.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,112,608,064.00	3,195,047,187.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,471,300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	64,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжл	620,748,864.00	446,706,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	491,099,200.00	1,103,496,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	109,343,787.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	80,694,300.00	12,832,900.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	80,694,300.00	12,832,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,694,300.00	12,832,900.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	80,694,300.00	12,832,900.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,694,300.00	12,832,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(80,694,300.00)	(12,832,900.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		-	-
71603 - Эрүүл мэндийн бодлого, удирдлага		2,495,512,100.00	2,634,705,965.00
80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал		921,075,300.00	1,060,269,165.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	921,075,300.00	1,060,269,165.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	921,075,300.00	1,060,269,165.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	921,075,300.00	1,060,269,165.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,146,300.00	554,146,300.00
210101	Үндсэн цалин	328,769,600.00	328,769,600.00
210102	Нэмэгдэл	132,171,300.00	132,171,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,890,000.00	43,890,000.00
210104	Урамшуулал	49,315,400.00	49,315,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,109,800.00	72,109,800.00
210201	Тэтгэврийн даатгал	50,743,900.00	50,743,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,341,500.00	5,341,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,273,200.00	4,273,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,068,300.00	1,068,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,682,900.00	10,682,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,699,800.00	42,699,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,164,500.00	5,164,500.00
210302	Түлш, халаалт	34,369,900.00	34,369,900.00
210303	Цэвэр, бохир ус	3,165,400.00	3,165,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,065,700.00	37,065,700.00
210401	Бичиг хэрэг	6,957,600.00	6,957,600.00
210402	Тээвэр, шатахуун	21,221,000.00	21,221,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,403,800.00	2,403,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,442,900.00	1,442,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,040,400.00	5,040,400.00
2105	Нормативт зардал	110,671,300.00	249,865,165.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,085,600.00	247,279,465.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,585,700.00	2,585,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,990,400.00	56,990,400.00
210601	Багаж, техник хэрэгсэл	11,820,100.00	11,820,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,673,000.00	2,673,000.00
210604	Урсгал засвар	42,497,300.00	42,497,300.00
2107	Томилолт, зочны зардал	13,683,100.00	13,683,100.00
210702	Дотоод албан томилолт	13,683,100.00	13,683,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	12,006,900.00	12,006,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,728,400.00	1,728,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	311,100.00	311,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,000.00	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,801,000.00	9,801,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	75,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	59,400.00	59,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,702,000.00	21,702,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,389,900.00	10,389,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,312,100.00	11,312,100.00
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		1,550,963,400.00	1,550,963,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,550,963,400.00	1,550,963,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,550,963,400.00	1,550,963,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,550,963,400.00	1,550,963,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,550,963,400.00	1,550,963,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	446,706,600.00	446,706,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,103,496,800.00	1,103,496,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	760,000.00	760,000.00

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

83112 - Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал		23,473,400.00	23,473,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,473,400.00	23,473,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,473,400.00	23,473,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,473,400.00	23,473,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,473,400.00	23,473,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,473,400.00	23,473,400.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		-	-
71603 - Эрүүл мэндийн бодлого, удирдлага		-	2,108,928,555.17
80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал		-	459,024,298.17
	Татварын бус орлого	-	1,462,872,803.99
	Тусламж, санхүүжилтийн орлого	-	1,462,872,803.99
	Төсвөөс санхүүжих	-	1,462,872,803.99
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	459,024,298.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	459,024,298.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	459,024,298.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	38,328,933.00
210102	Нэмэгдэл	-	38,328,933.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,273,700.00
210201	Тэтгэврийн даатгал	-	2,273,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	37,482,800.00
210402	Тээвэр, шатахуун	-	7,732,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	950,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	28,800,000.00
2105	Нормативт зардал	-	211,198,896.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	211,198,896.00
2107	Томилот, зочны зардал	-	26,776,800.00
210702	Дотоод албан томилот	-	26,776,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	142,963,169.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	142,963,169.17
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		-	1,644,083,787.00
	Татварын бус орлого	-	646,055,751.18
	Тусламж, санхүүжилтийн орлого	-	646,055,751.18
	Төсвөөс санхүүжих	-	646,055,751.18
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,644,083,787.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,644,083,787.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,644,083,787.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,644,083,787.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,471,300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	64,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	108,583,787.00
83112 - Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал		-	5,820,470.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	5,820,470.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,820,470.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,820,470.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,820,470.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,820,470.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн сайжруулах талаар 2 зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 73 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн хэмжээний нийгмийн эрүүл мэндийн болон эмнэл зүйн тусламж үйлчилгээ, эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор мөнгөн болон хөрөнгийн санхүүжилт, зардлын хэмжээ 4.3 дахин өссөн боловч тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч 2011 онд батлагдсан тул зарим өөрчлөлтийг хийж шинэчлэх шаардлагатай болсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн газрын даргын 2012 оны А/69 дүгээр тушаалаар баталсан "Байгууллагын үйл

ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг мөрдөж ажилладаг. Шинэчлэх шаардлагатай болсон тул журмын төсөл боловсруулсан байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,850.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 19.9 сая төгрөгөөр тогтоосон.

Суурь үзүүлэлтээр сонгосон нийт зардлын хэмжээнд тайлант онд эрс өөрчлөлт орсон тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Нийт зардлын хэмжээ 2021 онд 12,235.8 сая төгрөг болж өөрчлөгдсөн тул түүний 1.0 хувиас 70.0 хувиар тооцож гүйцэтгэлийн материаллаг түвшинг 85.6 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 284.8 сая төгрөгөөр өссөн байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтаар 96.0 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээн авсан, хөрөнгө оруулалтаар баригдсан 176.0 сая төгрөгийн үнэ бүхий эмийн агуулахын барилгыг ашиглалтад оруулсантай холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 578.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эм, тусгай зориулалтын материал хөрөнгө оруулалтаар огцом өссөнөөс шалтгаалжээ.
- Оны эхний 3.1 сая төгрөгийн авлагыг барагдуулсан боловч урсгал засвар хийлгэхээр гэрээ байгуулж мөнгө шилжүүлээд барилгын материалын хомсдолоос шалтгаалан хугацаандаа хийгдээгүй 16.0 сая төгрөгийн фасадын засварын зардлын авлага үүссэнийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.
- Тайлант онд өглөгийн үлдэгдэлгүй гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, Эрүүл мэндийн яаманд нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 2,617.2 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 2,495.5 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 2,495.5 сая төгрөгөөр батлагдаж, санхүүжилт бүрэн ирсэн ба оны нийт төсвийн гүйцэтгэл 2,495.5 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилт тайлант онд 2,248.1 сая төгрөг, тухайлбал:

- Засаг даргын нөөцөөс цар тахлын нөхцөл байдалтай холбоотой санхүүжилт 305.8 сая,
- Дээд шатны байгууллага болох ЭМЯ-наас аймгийн хэмжээний эрүүл мэндийн ажилтнуудын урамшуулал, илүү цагийн хөлс зэрэг зардалд 1,640.7 сая,
- Байгууллагын өөрийн орлого 141.6 сая төгрөг /үүнээс 139.2 сая нь төлбөртэй шинжилгээний орлого/,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 160.0 сая төгрөг /ДЭМБ-аас 143.9 сая, МСЭМ-ийн холбооноос 16.1 сая/ тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

- Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалын 3 дугаар заалтаар тодорхойлсон зардлын зүйлийг зөрчиж, коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний төлбөрийн 11.6 сая төгрөгийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан.
- Бараа материалын дансанд 25.3 сая төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэснээр хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.
- Төрийн санд орлого тушаалгахад иргэдийг чирэгдүүлэх, зарцуулах эрх нээлгэх хүндрэлээс шалтгаалж шинжилгээний төлбөрийн 139.2 сая төгрөгийн орлогыг байгууллагын арилжааны банкин дахь картын дансанд төвлөрүүлсэн байна. Энэ талаар тус байгууллагаас албан бичгээр ирүүлсэн тайлбарыг хавсаргав.
- Бараа материалын тайланд 29.9 сая төгрөгийн шатахууныг талоны дэвсгэртээр тусгаж байгаагаас машин бүрийн зарцуулалтыг нормтой харьцуулж тооцоо хийхэд ойлгомжгүй байдалтай, хяналт тавихад хүндрэлтэй байна.
- Эмч нарын орон сууцны ашиглалтад ороогүй хэсгийг барилга, орон сууц дансанд бүртгэснийг залруулж, дуусаагүй барилга дансанд тусгууллаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Эрүүл мэндийн газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж, хариуг албан тоотоор ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор ДЭМБ-аас “Ковид-19 цар тахлын эсрэг Өвөрхангай аймгийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд нийт 143.8 сая төгрөгийн санхүүжилт ирсэн. Үүний 73.1 хувь нь цалингийн нэмэлт урамшуулал хэлбэрээр зарцуулагдсан ба тус байгууллагаас олгож буй санхүүжилтийн зориулалтад анхаарал хандуулах шаардлагатай.
- 2021 онд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагын цалин, урамшууллын талаар нэг удаагийн шинж чанартай шийдвэрүүд олон удаа гарсан, тэдгээрийн зарим нь 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа тул цалин, урамшууллын зардлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 308.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Эмч нарын орон сууцны зарим хэсэг болох ашиглалтад ороогүй 102.0 сая төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилга дансанд бүртгүүлж, тайланг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

- Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалын 3 дугаар заалтыг мөрдөж, коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний төлбөрийн орлогыг тушаалд заасан зориулалтаар зарцуулж байх
- Нэгтгэсэн дүнгээр бүртгэсэн бараа материалыг хөрөнгө нэг бүрээр бүртгэж, тооллогод хамруулан, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах
- Шатах тослох материалыг бараа материалд бүртгэх болон зарцуулахдаа талоны дэвсгэртээр бус, шатахууны хэмжих нэгжээр тусгаж, тайлагнаж байх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого төвлөрүүлэлтийн асуудал

1.1. Илрүүлэлт:

Төрийн санд орлого тушаалгахад иргэдийг чирэгдүүлэх, зарцуулах эрх нээлгэх хүндрэлээс шалтгаалж шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын арилжааны банкин дахь картын дансанд төвлөрүүлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт, Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалыг мөрдөж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн газар	5	308.0	1	102.0			3	66.8	1	139.2

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН

